ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

**Дашбалбар сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

**Аудитын код: ДОА-2021/3/СТА-ТТ3**

---

Цахим хуудас: www.audit.mn
Чойбалсан хот
2021 он


Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер: И.Сэмжидмаа
Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Нармандах
Утас: 7058-4207, Цахим хаяг:narmandakhd@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| ДОА | Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар |

## Агуулга

1.Хараат бус аудиторын дүгнэлт....3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан....5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан....5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан....6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан....10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан....10
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан....11
3. Аудитын тайлан....12
3.1. Ерөнхий зүйл....12
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй....12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт....12
3.4. Материаллаг байдал....12
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд....13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт....14
3.7. Шилэн дансны мэдээлэл....15
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт....15
3.9. Аудитын илрүүлэлт....15
Залруулсан алдаа....15
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил....15
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд....16
4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт....16

## 1.Хараат бус аудиторын дүгнэлт

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000. Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2021.03.24 № 366

танай__________-ны №______________-т

ДАШБАЛБАР СУМЫН ЗАСАГ ДАРГА
Ж.ЁНДОНЖАМЦ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Дашбалбар сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дашбалбар сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дашбалбар сум нь 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтээр 83.1 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эцсийн үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,214,792,615.31** | **1,924,641,511.40** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 564,328,520.97 | 187,153,658.57 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 564,328,520.97 | 187,153,658.57 |
| **3121** | **Төгрөг** | 564,328,520.97 | 187,153,658.57 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 555,983,463.95 | 171,301,149.47 |
| 31213 | Арилжааны банк дахь харилцах | 8,345,057.02 | 15,852,509.10 |
| **33** | **АВЛАГА** | 209,895,279.00 | 259,963,980.00 |
| 33400 | Зээлийн хүүгийн авлага | 8,183,621.00 | 9,375,633.63 |
| **335** | **Бусад авлага** | 201,711,658.00 | 250,588,346.37 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 201,711,658.00 | 250,588,346.37 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 440,568,815.34 | 1,477,523,872.83 |
| **351** | **Түүхий эд материал** | 6,597,983.11 | 5,991,333.11 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 6,597,983.11 | 5,991,333.11 |
| **354** | **Хангамжийн материал** | 275,233,566.23 | 1,313,879,273.72 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,328,740.00 | 1,195,200.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 257,094,018.03 | 242,507,843.52 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 3,240,940.00 | 1,140,940.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 961,560.20 | 273,076.20 |
| 35450 | Барилгын засварын материал | 1,372,000.00 | 973,761,953.80 |
| 35460 | Хүнсний материал | - | 9,216,028.20 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 11,236,308.00 | 85,784,232.00 |
| 35600 | Мал амьтад | 158,737,266.00 | 157,653,266.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **5,867,424,990.38** | **6,248,964,275.65** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 5,867,424,990.38 | 6,248,964,275.65 |
| 391 | Газар | | |
| **392** | **Биет хөрөнгө** | 5,743,853,843.53 | 6,125,869,068.77 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 4,477,681,920.46 | 5,223,801,185.46 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (288,866,114.09) | (549,785,487.29) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 307,637,285.00 | 386,037,285.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (170,418,435.62) | (209,035,499.02) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 514,741,177.20 | 631,620,898.51 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (408,402,177.80) | (448,222,746.90) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 183,786,588.70 | 201,941,077.12 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (125,595,112.59) | (141,825,095.77) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 947,312,653.99 | 1,037,171,466.99 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | (348,599,928.81) | (416,035,359.02) |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 1,050,626.00 | 1,050,626.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 329,100,223.00 | 455,563,323.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (56,261,247.91) | (74,156,291.31) |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | 353,209,600.00 | - |
| 39217 | Ном | 27,476,786.00 | 27,743,686.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 123,571,146.85 | 123,095,206.88 |
| 39301 | Програм хангамж | 4,367,200.00 | 4,617,200.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (2,114,053.15) | (2,839,993.12) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 121,318,000.00 | 121,318,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **7,082,217,605.69** | **8,173,605,787.05** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **7,082,217,605.69** | **8,173,605,787.05** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 7,082,217,605.69 | 8,173,605,787.05 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,605,979,959.26 | 1,605,979,959.26 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 4,076,208,879.28 | 5,167,597,060.64 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 2,826,538,109.05 | 4,076,208,879.28 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 1,249,670,770.23 | 1,091,388,181.36 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,400,028,767.15 | 1,400,028,767.15 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **7,082,217,605.69** | **8,173,605,787.05** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **5,100,060,586.65** | **8,539,897,741.64** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **496,119,116.12** | **170,447,670.51** |
| **110** | **Орлогын албан татвар** | 51,873,952.12 | 83,440,690.51 |
| **1100** | **Хувь хүний орлогын албан татвар** | 51,873,952.12 | 83,440,690.51 |
| 110002 | Үйл ажиллагааны орлого | 2,227,000.00 | 6,313,708.30 |
| 110003 | Хөрөнгийн орлого | | 37,881,749.68 |
| 110008 | Шууд бус орлого | 49,646,952.12 | 39,245,232.53 |
| **113** | **Хөрөнгийн албан татвар** | 4,095,000.00 | 3,200,000.00 |
| 113002 | Бууны албан татвар | 4,095,000.00 | 3,200,000.00 |
| **118** | **Бусад татвар, төлбөр, хураамж** | 440,150,164.00 | 83,806,980.00 |
| **1180** | **Бусад нийтлэг төлбөр, хураамж** | 7,143,164.00 | 4,068,501.00 |
| 118001 | Улсын тэмдэгтийн хураамж | 5,011,164.00 | 4,068,501.00 |
| 118006 | Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр | 2,132,000.00 | - |
| **1181** | **Газрын төлбөр** | 370,670,000.00 | 24,151,479.00 |
| 118101 | Газрын төлбөр | | 24,151,479.00 |
| 118102 | Дуудлага худалдаа | 370,670,000.00 | - |
| **1182** | **Байгалийн нөөц ашигласны төлбөр** | 62,337,000.00 | 55,587,000.00 |
| 118202 | Ан амьтны нөөц ашигласны төлбөр | 19,600,000.00 | 12,800,000.00 |
| 118203 | Ус, рашааны нөөц ашигласны төлбөр | 42,737,000.00 | 42,787,000.00 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,785,879,672.27** | **3,655,186,441.94** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 1,446,879,672.27 | 3,337,662,441.94 |
| 120002 | Хүүгийн орлого | 29,550,273.06 | |
| 120003 | Торгуулийн орлого | 10,795,758.70 | 44,571,133.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,043,820,846.51 | 2,403,523,482.02 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,350,000.00 | 156,339,259.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,000,000.00 | 3,196,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 1,038,470,846.51 | 2,243,988,223.02 |
| 120009 | Бусад орлого | 114,538,100.00 | 850,427,189.00 |
| 120010 | Борлуулалтын орлого (цэвэр) /ТӨҮГ/ | 248,174,694.00 | 39,140,637.92 |
| **122** | **Тусламжийн орлого** | 339,000,000.00 | 317,524,000.00 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 14,000,000.00 | - |
| 122002 | Хандив тусламж /гадаад/ | 325,000,000.00 | 317,524,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,818,061,798.26** | **4,714,263,629.19** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,128,111,200.00 | 1,353,489,600.00 |
| 131004 | Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх | 1,180,200.00 | - |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,126,931,000.00 | 1,353,489,600.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 48,535,237.00 | 339,319,138.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, | - | 2,165,250.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 29,194,050.00 | 325,322,958.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон | 19,341,187.00 | 11,830,930.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 1,641,415,361.26 | 3,021,454,891.19 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 854,197,700.00 | 1,937,292,126.39 |
| 132003 | Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/ | 77,137,461.26 | 71,831,864.80 |
| 132006 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/ | 419,138,000.00 | 461,349,300.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 290,942,200.00 | 550,981,600.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **3,850,389,816.42** | **7,448,509,560.28** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **3,026,169,578.62** | **4,979,423,497.48** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,065,386,737.99 | 2,837,506,511.59 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,163,912,360.79 | 1,405,741,513.88 |
| 210101 | Үндсэн цалин | 923,302,859.65 | 1,063,730,263.12 |
| 210102 | Нэмэгдэл | 115,436,196.00 | 195,863,184.54 |
| 210104 | Урамшуулал | 82,456,925.98 | 93,157,629.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 42,716,379.16 | 52,990,437.22 |

| | | | |
|---|---|---|---|
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 150,030,774.09 | 176,423,506.79 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 102,908,422.23 | 118,123,090.56 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 11,886,057.66 | 13,262,859.61 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 9,455,026.12 | 9,758,382.63 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,347,981.38 | 3,870,895.21 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 23,433,286.70 | 31,408,278.78 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 87,550,295.90 | 81,540,710.70 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 16,655,094.70 | 17,034,181.25 |
| 210302 | Түлш, халаалт | 67,918,501.20 | 62,586,229.45 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,976,700.00 | 1,920,300.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 70,614,475.09 | 100,852,681.52 |
| 210401 | Бичиг хэрэг | 6,086,272.00 | 6,675,999.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 35,580,415.60 | 35,102,654.36 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 7,420,106.29 | 6,241,894.16 |
| 210404 | Ном, хэвлэл | 242,400.00 | 458,800.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 840,000.00 | 848,960.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 20,445,281.20 | 51,524,374.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 100,312,213.70 | 61,314,013.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 349,000.00 | 509,273.60 |
| 210502 | Хоол, хүнс | 99,626,213.70 | 56,588,739.40 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 337,000.00 | 4,216,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 11,260,170.00 | 11,064,568.00 |
| 210604 | Урсгал засвар | 11,260,170.00 | 11,064,568.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 13,105,500.00 | 3,326,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 13,105,500.00 | 3,326,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 26,288,011.65 | 37,002,874.84 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 8,669,250.00 | 3,700,190.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 680,000.00 | 1,030,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 374,720.00 | 341,050.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 216,800.00 | 227,524.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 154,000.00 | 55,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 6,300.00 | 15,925.00 |
| 210811 | Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/ | 16,186,941.65 | 31,633,185.84 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 442,312,936.77 | 960,240,642.86 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 51,883,563.00 | 513,793,110.40 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,967,700.00 | 608,490.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 387,461,673.77 | 445,839,042.46 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 960,782,840.63 | 2,141,916,985.89 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 29,371,159.00 | 35,923,392.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 27,931,159.00 | 23,530,092.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 11,327,800.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,440,000.00 | 1,065,500.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 931,335,161.26 | 2,009,123,991.19 |
| 213401 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага | 854,197,700.00 | 1,937,292,126.39 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 77,137,461.26 | 71,831,864.80 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 76,520.37 | 96,869,602.70 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 76,520.37 | 96,869,602.70 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **824,220,237.80** | **2,469,086,062.80** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 824,220,237.80 | 2,469,086,062.80 |
| 223001 | Бусад хөрөнгө | 824,220,237.80 | 2,469,086,062.80 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **1,249,670,770.23** | **1,091,388,181.36** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **1,249,670,770.23** | **1,091,388,181.36** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **3,962,513,291.14** | **6,240,782,963.62** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **496,119,116.12** | **170,447,670.51** |
| **110** | **Орлогын албан татвар** | 51,873,952.12 | 83,440,690.51 |
| **1100** | **Хувь хүний орлогын албан татвар** | 51,873,952.12 | 83,440,690.51 |
| 110002 | Үйл ажиллагааны орлого | 2,227,000.00 | 6,313,708.30 |
| 110003 | Хөрөнгийн орлого | | 37,881,749.68 |
| 110008 | Шууд бус орлого | 49,646,952.12 | 39,245,232.53 |
| **113** | **Хөрөнгийн албан татвар** | 4,095,000.00 | 3,200,000.00 |
| 113002 | Бууны албан татвар | 4,095,000.00 | 3,200,000.00 |
| **118** | **Бусад татвар, төлбөр, хураамж** | 440,150,164.00 | 83,806,980.00 |
| **1180** | **Бусад нийтлэг төлбөр, хураамж** | 7,143,164.00 | 4,068,501.00 |
| 118001 | Улсын тэмдэгтийн хураамж | 5,011,164.00 | 4,068,501.00 |
| 118006 | Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр | 2,132,000.00 | - |
| **1181** | **Газрын төлбөр** | 370,670,000.00 | 24,151,479.00 |
| 118101 | Газрын төлбөр | | 24,151,479.00 |
| 118102 | Дуудлага худалдаа | 370,670,000.00 | - |
| **1182** | **Байгалийн нөөц ашигласны төлбөр** | 62,337,000.00 | 55,587,000.00 |
| 118202 | Ан амьтны нөөц ашигласны төлбөр | 19,600,000.00 | 12,800,000.00 |
| 118203 | Ус, рашааны нөөц ашигласны төлбөр | 42,737,000.00 | 42,787,000.00 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **523,581,031.76** | **1,356,071,663.92** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 184,581,031.76 | 1,038,547,663.92 |
| 120002 | Хүүгийн орлого | 29,550,273.06 | - |
| 120003 | Торгуулийн орлого | 10,795,758.70 | 44,571,133.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 5,350,000.00 | 104,408,704.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,350,000.00 | 102,847,704.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,000,000.00 | 1,561,000.00 |
| 120005 | Түрээсийн орлого | 2,060,000.00 | - |
| 120009 | Бусад орлого | 129,538,000.00 | 860,427,189.00 |
| 120013 | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/ | 7,287,000.00 | 29,140,637.92 |
| **122** | **Тусламжийн орлого** | 339,000,000.00 | 317,524,000.00 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 14,000,000.00 | - |
| 122002 | Хандив тусламж /гадаад/ | 325,000,000.00 | 317,524,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,942,813,143.26** | **4,714,263,629.19** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,252,862,445.00 | 1,353,489,600.00 |
| 131004 | Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх | 125,931,445.00 | - |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,126,931,000.00 | 1,353,489,600.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 48,535,237.00 | 339,319,138.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | - | 2,165,250.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 29,194,050.00 | 325,322,958.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 19,341,187.00 | 11,830,930.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 1,641,415,461.26 | 3,021,454,891.19 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 854,197,700.00 | 1,937,292,126.39 |
| 132003 | Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/ | 77,137,461.26 | 71,831,864.80 |
| 132006 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/ | 419,138,100.00 | 461,349,300.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 290,942,200.00 | 550,981,600.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **2,612,877,152.65** | **4,405,205,027.22** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,612,877,152.65** | **4,405,205,027.22** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,652,094,312.02** | **2,260,918,041.33** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,169,614,229.57 | 1,415,200,991.68 |
| 210101 | Үндсэн цалин | 924,213,289.65 | 1,061,369,829.24 |
| 210102 | Нэмэгдэл | 115,436,196.00 | 195,863,184.54 |
| 210104 | Урамшуулал | 82,456,925.98 | 93,157,629.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 42,716,379.16 | 52,944,951.90 |
| 210106 | Ажилагчдад төлсөн /ТӨҮГ/ | 4,791,438.78 | 11,865,397.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 151,296,337.66 | 181,300,524.76 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 102,908,422.23 | 119,198,395.43 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 11,886,057.66 | 13,804,090.36 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 9,455,026.12 | 9,968,883.96 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,347,981.38 | 3,923,518.48 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 23,433,286.70 | 31,934,537.76 |
| 210206 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | 1,265,563.57 | 2,471,098.77 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 91,922,632.20 | 88,134,176.90 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 16,655,094.70 | 17,034,181.25 |
| 210302 | Түлш, халаалт | 67,918,501.20 | 61,760,752.58 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,976,700.00 | 1,920,300.00 |
| 210305 | Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/ | 4,372,336.30 | 7,418,943.07 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 68,083,281.89 | 67,009,389.39 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,734,672.00 | 6,378,959.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 34,969,392.60 | 35,126,701.23 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 7,252,506.29 | 6,241,894.16 |
| 210404 | Ном, хэвлэл | 884,700.00 | 491,400.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 840,000.00 | 848,960.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 14,554,521.00 | 9,610,130.00 |
| 210409 | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/ | 1,235,420.00 | 5,003,845.00 |
| 210410 | Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/ | 2,612,070.00 | 3,307,500.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 102,716,768.70 | 62,892,831.20 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 349,000.00 | 509,273.60 |
| 210502 | Хоол, хүнс | 99,348,768.70 | 58,028,557.60 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,019,000.00 | 4,355,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 20,874,900.00 | 9,730,010.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 6,582,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 14,292,900.00 | 9,730,010.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 13,105,500.00 | 3,326,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 13,105,500.00 | 3,326,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 15,147,133.00 | 7,086,091.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 11,805,200.00 | 3,850,190.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 680,000.00 | 1,030,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 374,720.00 | 341,050.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 216,800.00 | 227,524.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 154,000.00 | 55,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 6,300.00 | 15,925.00 |
| 210816 | Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | 791,713.00 | 494,410.00 |
| 210818 | Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/ | 1,118,400.00 | 1,071,992.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 19,333,529.00 | 426,238,026.40 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 16,276,529.00 | 424,425,056.40 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,057,000.00 | 1,812,970.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **960,782,840.63** | **2,144,286,985.89** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 29,371,159.00 | 38,293,392.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 27,931,159.00 | 25,900,092.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 11,327,800.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,440,000.00 | 1,065,500.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 931,335,161.26 | 2,009,123,991.19 |
| 213401 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага | 854,197,700.00 | 1,937,292,126.39 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 77,137,461.26 | 71,831,864.80 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 76,520.37 | 96,869,602.70 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 76,520.37 | 96,869,602.70 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **1,349,636,138.49** | **1,835,577,936.40** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **898,576,955.00** | **2,121,052,798.80** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **898,576,955.00** | **2,121,052,798.80** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 898,576,955.00 | 2,121,052,798.80 |
| 223001 | Бусад хөрөнгө | 854,272,755.00 | 2,112,453,608.80 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 44,304,200.00 | 8,599,190.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(898,576,955.00)** | **(2,121,052,798.80)** |
| **23** | **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | 104,780,000.00 | 91,700,000.00 |
| 230001 | Эргэж төлөгдөх зээл | 104,780,000.00 | 91,700,000.00 |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **104,780,000.00** | **91,700,000.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 346,279,183.49 | (377,174,862.40) |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 218,049,337.48 | 564,328,520.97 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 564,328,520.97 | 187,153,658.57 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | 2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,605,979,959.26 | 1,400,028,767.15 | 2,826,538,109.05 | 5,832,546,835.46 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | 0.00 | 0.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,605,979,959.26** | **1,400,028,767.15** | **2,826,538,109.05** | **5,832,546,835.46** |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 0.00 | 0.00 | | 0.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 0.00 | | | 0.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | 0.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | 1,249,670,770.23 | 1,249,670,770.23 |
| C08 | **2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,605,979,959.26** | **1,400,028,767.15** | **4,076,208,879.28** | **7,082,217,605.69** |
| D01 | **2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,605,979,959.26** | **1,400,028,767.15** | **4,076,208,879.28** | **7,082,217,605.69** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | 0.00 | 0.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,605,979,959.26** | **1,400,028,767.15** | **4,076,208,879.28** | **7,082,217,605.69** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | 0.00 | | 0.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 0.00 | | | 0.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | 0.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | 0.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | 1,091,388,181.36 | 1,091,388,181.36 |
| D09 | **2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,605,979,959.26** | **1,400,028,767.15** | **5,167,597,060.64** | **8,173,605,787.05** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 4,517,231,000.00 | 4,141,011,908.29 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 2,075,224,700.00 | 1,931,858,299.49 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,029,617,700.00 | 1,893,564,907.49 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,445,972,200.00 | 1,402,999,594.68 |
| 210101 | Үндсэн цалин | 1,092,498,000.00 | 1,061,369,829.24 |
| 210102 | Нэмэгдэл | 194,490,100.00 | 195,863,184.54 |
| 210104 | Урамшуулал | 106,761,700.00 | 92,821,629.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 52,222,400.00 | 52,944,951.90 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 184,406,600.00 | 178,829,425.99 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 127,067,500.00 | 119,198,395.43 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 12,797,300.00 | 13,804,090.36 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,027,700.00 | 9,968,883.96 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 8,933,600.00 | 3,923,518.48 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 28,580,500.00 | 31,934,537.76 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 104,687,900.00 | 80,715,233.83 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 19,992,100.00 | 17,034,181.25 |
| 210302 | Түлш, халаалт | 80,626,000.00 | 61,760,752.58 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,069,800.00 | 1,920,300.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 65,394,700.00 | 51,929,165.39 |
| 210401 | Бичиг хэрэг | 6,801,800.00 | 5,646,029.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 35,779,200.00 | 32,668,562.23 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 7,683,000.00 | 6,121,894.16 |
| 210404 | Ном, хэвлэл | 1,269,000.00 | 758,300.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариут | 2,210,000.00 | 848,960.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 11,651,700.00 | 5,885,420.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 92,327,500.00 | 62,892,831.20 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,575,000.00 | 509,273.60 |
| 210502 | Хоол, хүнс | 84,162,500.00 | 58,028,557.60 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 6,590,000.00 | 4,355,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 11,510,100.00 | 11,419,810.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 7,000,000.00 | 7,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,510,100.00 | 4,419,810.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 4,123,000.00 | 2,706,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,123,000.00 | 2,706,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, ху** | 17,816,200.00 | 3,815,689.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээни | 15,527,100.00 | 2,146,190.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,210,000.00 | 1,030,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 433,300.00 | 341,050.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 417,900.00 | 227,524.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 210,000.00 | 55,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 17,900.00 | 15,925.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 103,379,500.00 | 98,257,157.40 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 101,279,500.00 | 96,194,187.40 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,100,000.00 | 2,062,970.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 45,607,000.00 | 38,293,392.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 45,607,000.00 | 38,293,392.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 33,184,400.00 | 25,900,092.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 11,327,800.00 | 11,327,800.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,094,800.00 | 1,065,500.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **2,154,661,900.00** | **2,117,453,608.80** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 2,154,661,900.00 | 2,117,453,608.80 |
| 223001 | Бусад хөрөнгө | 2,154,661,900.00 | 2,117,453,608.80 |
| **23** | **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭ** | 287,344,400.00 | 91,700,000.00 |
| 230001 | Эргэж төлөгдөх зээл | 287,344,400.00 | 91,700,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 4,517,231,000.00 | 4,094,994,562.89 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,353,489,600.00 | 1,256,619,997.30 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,353,489,600.00 | 1,256,619,997.30 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 2,067,204,000.00 | 2,416,441,861.59 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 1,516,222,400.00 | 1,865,460,261.59 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 550,981,600.00 | 550,981,600.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 779,013,400.00 | 104,408,704.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 243,288,900.00 | 102,847,704.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,505,000.00 | 1,561,000.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 534,219,500.00 | |
| **122** | **ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ** | 317,524,000.00 | 317,524,000.00 |
| 122002 | Хандив тусламж /гадаад/ | 317,524,000.00 | 317,524,000.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **48,535,237.00** | **344,319,138.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **18,840,787.00** | **344,319,138.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 18,600,787.00 | 344,319,138.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 179,000.00 | 336,000.00 |
| 210104 | Урамшуулал | 179,000.00 | 336,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 5,117,587.00 | 7,868,069.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 63,000.00 | 732,930.00 |
| 210402 | Түлш, шатахуун | 802,577.00 | 2,458,139.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | - | 120,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 200,000.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,052,010.00 | 4,557,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 6,219,100.00 | 5,310,200.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 910,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 5,309,100.00 | 5,310,200.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 928,000.00 | 620,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 928,000.00 | 620,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 5,157,100.00 | 1,954,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,157,100.00 | 1,954,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,000,000.00 | 328,230,869.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,000,000.00 | 328,230,869.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 240,000.00 | - |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 240,000.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 240,000.00 | - |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **29,694,450.00** | - |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 29,694,450.00 | - |
| 223001 | Бусад хөрөнгө | 28,792,450.00 | - |
| 225001 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 902,000.00 | - |

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасан бүрэн эрхийн хүрээнд Дашбалбар сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Ж.Ёндонжамц танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 10-наас 2021 оны 03 дугаар сарын 24-ны хооронд Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Нармандах хариуцаж хэрэгжүүлэв.

Дашбалбар сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 1/146 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Дашбалбар сумын Засаг Даргын Тамгын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Харьяалах нутаг дэвсгэрийнх нь эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлаар төрийн эрх бүхий байгууллагаас батлах төсөл, хөтөлбөрт санал өгөх, тэдгээрийн хэрэгжилтийг зохион байгуулах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Дашбалбар сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү, хяналт аудитын алба 2020 онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Дашбалбар сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлын 7,448,509.6 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 148,970.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

## 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дашбалбар сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,091,388.2 мянган төгрөгөөр буюу 15.4 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 564,328.5 | 187,153.7 | -377,6174.9 |
| Авлага | 209,895.3 | 259,964.0 | 50,068.7 |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 440,568.8 | 1,477,523.9 | 1,036,955.1 |
| Үндсэн хөрөнгө | 5,867,425.0 | 6,248,964.3 | 381,539.3 |
| **Нийт хөрөнгө** | **7,082,217.6** | **8,173,605.8** | **1,091,388.2** |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 7,082,217.6 | 8,173,605.8 | 1,091,388.2 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **7,082,217.6** | **8,173,605.8** | **1,091,388.2** |

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 187,153.7 мянган төгрөг болж өмнөх оноос 377,6174.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Авлага дансны үлдэгдэл 259,964.0 мянган төгрөг болж 50,068.7 мянган төгрөгөөр өссөн нь Сум хөгжүүлэх сангаас зээл олгосонтой холбоотой байна. Авлага дансны үлдэгдэл 259,964.0 мянган төгрөг нь төсөл сантай холбоотой хувь хүмүүсээс авах зээл, зээлийн хүүгийн авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 1,477,523.9 мянган төгрөг болж 1,036,955.1 мянган төгрөгөөр өссөн нь Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж буй Буриадын өв соёлын музейн барилга, сургуулийн хөл бөмбөгийн талбайн, цахилгаан дамжуулах агаарын шугамын ажлыг дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгэсэнтэй холбоотой байна. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 6,248,964.3 мянган төгрөг болж 381,539.3 мянган төгрөгөөр өссөн нь хөрөнгө оруулалт хийгдсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс нь хөрөнгө оруулалтаар 371,925.7 мянган төгрөг, урсгал төсвийн худалдан авалтаар 8,599.2 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 1,010.0 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө нь үнэ төлбөргүй шилжүүлсэн 353,209.6 мянган төгрөг, акталсан 4,195.6 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Биет бус хөрөнгийн дансны үлдэгдэл 123,095.2 мянган төгрөг байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 0 төгрөг байна.

Урт хугацаат өр төлбөр байхгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 8,173,605.8 мянган төгрөг болж 1,091,388.2 мянган төгрөгөөр өссөн нь хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна.

Дашбалбар сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 3,439,837.2 мянган төгрөгөөр буюу 67.4 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 3,598,119.7 мянган төгрөгөөр буюу 93.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй ирсэн хөрөнгийн орлого, шүүхийн шийдвэрээр хэлмэгдүүлэлтийн мөнгө олгосон, бараа үйлчилгээний бусад болон үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй байна.

## 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### Төсвийн төлөвлөлт

Дашбалбар сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 4,517,231.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 4,517,231.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвөөс 4,517,231.0 мянган төгрөгөөр баталсан байна.

### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 5 хөтөлбөрийн 18 арга хэмжээг санхүүжүүлэхээр 4,517,231.0 мянган төгрөгийн төсөв баталснаас төсвөөс 3,420,693.6 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 779,013.4 мянган төгрөг, хандив тусламжаас 317,524.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 4,141,011.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагааны зарцуулалт 100 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого

Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд зааснаар 2020 онд 1,054,873.1 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 1,065,446.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 101 хувиар биелүүлсэн байна.

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 332,488.2 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 11,830.9 мянга, нийт 344,319.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс урамшуулалд 336.0 мянга, хангамж,бараа материалын зардалд 7,868.1 мянга, эд хогшил, урсгал засварын зардалд 5,310.2 мянга, дотоод албан томилолт 620.0 мянга, төлбөр хураамж 1,954.0 мянга, бусад зардалд 328,230.9 мянга, нийт 344,319.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс 10 мэдээлэл хугацаа хоцроон мэдээлсэн байна. Мөн түүвэрт хамрагдсан Дашбалбар хөгжил ОНӨААН 2 нэр төрлийн 64,278.6 мянган төгрөгийн, ОНХС 2 нэр төрлийн 57,583.2 мянган төгрөгийн хөрөнгийн орлогыг, СХС-гаас олгосон 25 иргэнд олгосон 91,700.0 мянган төгрөгийн зээлийг тус тус www.shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулаагүй байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 959.8 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлагыг биелүүлсэн байна.

*Хүснэгт 3* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган.төг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | - | - | - | - | - | - | |
| Албан шаардлага | 1 | 959.8 | 1 | 959.8 | - | - | 100 |
| Зөвлөмж | - | - | - | - | - | - | - |
| **Нийт дүн** | 1 | 959.8 | 1 | 959.8 | - | - | 100 |

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 62,320.0 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүллээ.

#### Залруулсан алдаа

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй болно.

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар үйл ажиллагаатай холбоотой 62,320.0 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Сумын Засаг даргын захирамжаар нийт 21,000.0 мянган төгрөгийг тухайн шатны төсөвт хамаарах ч урьдчилан төлөвлөх боломжтой, нэг удаагийн бус шинж чанартай арга хэмжээнд зарцуулсан нь Сангийн Сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөцийн хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам"-ын 1.2 дахь “Энэ журмын 1.1-д заасан “урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан” гэдгийг жил бүр давтагддаггүй онцгой арга хэмжээ, тохиолдлыг төсвийн зардлын зүйлс, арга хэмжээний

ангиллын дагуу санхүүжүүлэх боломжгүй нөхцөл байдал гэж ойлгоно" гэсэн заалтад нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

2. Санхүүгийн тайланд тусгагдсан авлагын 15.9 хувь буюу 41,320.0 мянган төгрөг нь хугацаа хэтэрсэн нь байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах, 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтад нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

### Аудитын зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй болно.

## 3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй болно.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| Огноо: | Аудитын нэр: | Дашбалбар сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит | Аудитын код: |
|---|---|---|---|
| 2020 | | | ДОА-2021/3/СТА-ТТЗ |
| Шалгагдсан байгууллагын нэр: | | Дашбалбар сумын ТТЗ | Мянган төгрөгөөр |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Сумын Засаг даргын захирамжаар тухайн шатны төсөвт хамаарах ч урьдчилан төлөвлөх боломжтой, нэг удаагийн бус шинж чанартай арга хэмжээнд зарцуулсан. | 21,000.0 | Албан шаардлага хүргүүлэв. | Санхүүгийн албаны дарга | Д.Баярцэцэг |
| 2 | Санхүүгийн тайланд тусгагдсан авлагын 15.9 хувь нь хугацаа хэтэрсэн нь байна | 41,320.0 | Албан шаардлага хүргүүлэв. | Санхүүгийн албаны дарга | Д.Баярцэцэг |
| 4 | Түүвэрт хамрагдсан Дашбалбар хөгжил ОНӨААН 2 нэр төрлийн 64,278.6 мянган төгрөгийн, ОНХС 2 нэр төрлийн 57,583.2 мянган төгрөгийн хөрөнгийн орлогыг, СХС-гаас олгосон 25 иргэнд олгосон 91,700.0 мянган төгрөгийн зээлийг тус тус www.shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулаагүй. | - | Албан шаардлага хүргүүлэв. | Санхүүгийн албаны дарга | Д.Баярцэцэг |
| **ДҮН** | | **62,320.0** | | | |